



**МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ ЖУРАМ, ДҮРЭМ
БАТЛАХ ТУХАЙ /“Усан замын зогсоол байгуулах, түүнийг ашиглах журам”, “Усан замын
тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм”/**

2005 оны 2 дугаар сарын 07-ны
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 23

Усан замын тээврийн тухай хуулийн 6.1.3, 6.1.5 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Усан замын зогсоол байгуулах, түүнийг ашиглах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч болон ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм”-ийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг гарсантай холбогдуулан уг журам, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тээврийн бодлого, зохицуулалтын газар /Н.Нямдаваа/-т даалгасугай.

САЙД Г.БАТХҮҮ

Тус тушаалын 2-р хавсралтыг 2006 оны 111-р тушаалаар хүчингүй болгосон/

**Зам, тээвэр, аялал жуучлалын сайдын
2005 оны 23 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт**

УСАН ЗАМЫН ЗОГСООЛ БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Усан замын зогсоолын цогцолборын бүтцэд тасалбар борлуулах цэг, тээш хадгалах газар, хүлээлгийн танхим, зочид буудал, лавлах, худалдааны цэг болон зоогийн газар гэх мэт соёлын болон ахуйн хангамжийн газрууд байж болно.

2. Зогсоолын газар дараах үндсэн зорилтод нийцсэн байна. Үүнд:

а/ачаа ачих, буулгах ажлыг гүйцэтгэх, зогсоолын дамжин өнгөрөх тээврийн хэрэгсэл үйлчилгээ үзүүлэх;

б/зогсоолын аж ахуйг хөгжүүлэх;

в/зогсоол болон усан замын тээврийн хэрэгслийг механикжуулах, автоматжуулах, хөдөлмөр хөнгөвчилсөн дэвшилтэт технологи нэвтрүүлэх;

г/зогсоол хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагаа, үйлчилгээг зохион байгуулах;

д/зогсоолд хамаарах бусад туслах үйлдвэр, аж ахуйн ажлыг зохион байгуулах;

е/ачих, буулгах, засвар хийх, техник ашиглалтын болон бусад ажил үйлчилгээний аюулгүй байдлыг хангах, усан замын тээврийн хэрэгслийн аваар аюулгүй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бий болгох;

ё/зогсоол болон усан замын тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдлыг хангах, гал түймэр, аваар ослын үед багийн гишүүд, зогсоолын ажилтныг зохион байгуулах;

ж/навигацийн болон техникийн үйлчилгээг иж бүрэн хангах.

3. Зогсоолын үйл ажиллагаа явуулах газар, байршлыг орон нутгийн засаг захиргааны байгууллагаас тогтооно.

Зогсоолд тавигдах ерөнхий шаардлага

4.Зогсоол нь тээвэрлэгдэж буй зорчигч, ачааны онцлог, төрөл зүйл болон зогсоолын зэрэглэлд тохирхуйц техник төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

5.Зогсоолын нутаг дэвсгэрт дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

а/зогсоолын байгууламж, тоног төхөөрөмж, байшин барилга чөлөөтэй байрлаж байх;

б/зогсоолтой холбоотой аливаа үйлчилгээг түргэн шуурхай, аюул осолгүй явуулах талбайтай байх;

в/зогсоолын нутаг дэвсгэрийн хүрээнд авто машины зам, ачих-буулгах тоног төхөөрөмж, төмөр зам ба ачаа барааг хадгалах боломж бүхий хатуу хучилттай замтай байх;

в/борооны болон бусад ус зайлуулах хоолой, бохир усны шугамтай байх;

г/ зэргэлдээх нутаг дэвсгэрээс хаалт, хашаагаар тусгаарлагдсан байх;

е/усан замын тээврийн хэрэгслээс хуурай хог, тээвэрлэгдсэн ачаа, барааны үлдэгдэл хогийг гарган авч зайлуулах газартай байх.

6.Зогсоол нь аврах хэрэгслээр бүрэн хангагдсан байхаас гадна аврах баг бүрэлдэхүүнтэй байвал зохино.

7. Зогсоол дахь усан замын тээврийн хэрэгсэлд үйлчилгээ үзүүлэх, зогсоол руу ирэх болон түүнээс хөдлөх бүрэлдэхүүнийг байршуулах, зогсоолын аж ахуй, ачих, булгах үйл ажиллагааг хийж гүйцэтгэх мэргэшсэн багтай байна.

8. Зогсоолын усны гүний хэмжээг тухайн зогсоолын зориулалт, үйлчлүүлэх тээврийн хэрэгслийн овор хэмжээ, төрөл зүйл, усан замын онцлог, усны ёроолын хөрсний байдал, гүний хэмжээ, давлагаа, хаялга зэргийг тооцоолсны үндсэн дээр усан замын удирдлага тогтооно.

9. Зогсоол руу орох, гарах замыг зохистой зайд байрлуулсан хөвүүр торхнууд дээр сайтар бөхлөгдсөн тэмдгээр хашиж өдөр, шөнийн аль ч нөхцөлд тод гэрэлтэж байхаар тоноглогдсон байна.

10. Хөвдөг зогсоолыг зорчигчийн суух болон буухад зориулсан бариултай шатаар тоноглогдсон байх ба зогсоолыг эрэгт хоёр талаас нь найдвартай бэхэлж тогтоосон байна.

11. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, тэдгээрийн хэвийн ажиллагаа, үйлчилгээний зохион байгуулалт, ачилт буулгалтыг тухайн тээврийн хэрэгслийн ахмад буюу тээврийн хэрэгслийг жолоодогч хариуцна.

12. Зогсоол нь усан замын тээврийн хэрэгслээс гарсан бохир ус, тос, нефтийн төрлийн бүтээгдэхүүний үлдэгдэл, мод болон бусад бохирдлыг уснаас цэвэрлэж байх зориулалт бүхий /өөрөө явагч болон бусад/ хэрэгсэлтэй байна.

13. Зогсоол дээр усан замын тээврийн хэрэгслийг хамгаалах зориулалт бүхий байгууламж, хаалтын болон хамгаалах тоног төхөөрөмж /далан, давлагаа бууруулагч, мөс зүсэгч/-ийг суурилуулж болох ба гол ус үерлэх, усны түвшин нэмэгдэх үеэр дээрх төхөөрөмж далдлагдвал дарагдсан хэсгийг тойруулан анхааруулах тэмдэг тавина.

14. Зогсоол буюу хөвдөг зогсоолыг давлагаа, цэнгийн түрэлтээс хамгаалсан зөөлөн урсгалтай газар байгуулна.

Зогсоолын усан дотор байрлах хэсэг

15. Усан дотор байрлах хэсэг нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:

- а/ зогсоолын нутаг дэвсгэрийн тээврийн хэрэгслийн багтаамж, усны гүн тодорхой шаардлагын дагуу бэлтгэгдсэн байх;
- б/ усан замын тээврийн хэрэгсэлтэй шууд харилцах боломжийг бүрдүүлсэн налуу, усан замын тээврийн хэрэгсэл ирэх буцах аюулгүйн гарц, шатаар хангагдсан байх;
- в/ харилцаа холбоо, гэрэлтүүлэгтэй байх;
- г/ галын аюулаас сэргийлэх төрөл бүрийн багаж хэрэгслээр хангагдсан, галын байгууллагын машинд зориулсан тусгай зогсоолтой байх;
- д/ инженерийн шугам сүлжээ /ус дамжуулах хоолой, суваг, шуудуу/, гал түймрийн үед усан сан руу орох орц, галын автомашиныг байрлуулах зогсоолтой байх;
- е/ зогсоолын хил хязгаарыг тэмдэглэсэн анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ нь өдөр болон шөнийн цагт тод харагддаг байх.

Аврах болон галын хэрэгсэл

16. Эргийн болон хөвдөг хэрэгслүүдэд заавал байх аврах хэрэгсэл нь бүрэн бүтэн байх ба тогтоосон нормын дагуу будагдаж, байрлуулагдсан байна.

17. Гал түймрийн үед хэрэглэх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, дохио дохиолол нь галын аюулгүй байдлын норм, галын байгууллагын шаардлагад нийцсэн тоо хэмжээтэй

гал түймэртэй тэмцэх байгууллагын шаардлагын дагуу байршуулагдсан байх ба тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг Зогсоолын захиргааны зүгээс тогтмол шалгаж байвал зохино.

Зогсоолын ажилтны эрх, үүрэг

18. Хөдөлгөөний аюулгүй байдал, зогсоол, усан замын тээврийн хэрэгсэлтэй харьцах аюулгүй байдлыг боомт, зогсоолын удирдлага хариуцна.

19. Механикжсан ачилт буулгалт бүхий зогсоолд зогсох усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн тоног, төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг тухайн зогсоолыг эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн /цаашид зогсоолын захирга гэх мэт/ хариуцна.

20. Зогсоолын аж ахуйн тодорхой объектын бүрэн бүтэн байдлыг тухайн объектыг удирдаж буй албан тушаалтан хариуцна.

21. Усан замын тээврийн хэрэгслийг ойртон ирэх хэсгийн гүний хэмжээг зогсоолын удирдлага байнга хянаж ёроолыг нь гүнзгийлэх болон цэвэрлэх ажлыг тухай бүр зохион байгуулахаас гадна ус татарсан хэсгийн эргийн цэвэрлэгээг хариуцан ажиллана.

**Зам, тээвэр, аялал жуучлалын сайдын
2005 оны 23 дугаар тушаалын 3 дугаар хавсралт**

**УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН АШИГЛАЛТЫН
ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн нуур, гол, мөрний усанд ашиглагдаж байгаа усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага, түүнийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Энэхүү дүрмийг усан замын тээврийн хэрэгсэл, зогсоолыг эзэмшигч усан замын тээврийн аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн нийт ажилтан дагаж мөрдөх үүрэгтэй.

3. Энэхүү дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

4. Гол, мөрөн, нуур цөөрөмд хийгдэж буй усан замын тээвэр /цаашид усан замын тээвэр гэх/-ийн болон түүнд холбоотой шинээр гарах аливаа нэгэн техник ашиглалтын дүрэм, зааврууд энэхүү дүрмийн заалтуудын агуулга, зарчимд нийцсэн байвал зохино.

5. Усан замын тээврийн аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн ажилтан нь усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдал, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангаж, хүн ам, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэн ажиллах үүрэгтэй.

**Хоёр. Усан замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, байгууллага,
тэдгээрийн ажилтны үүрэг**

6. Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд ачаа болон зорчигч тээвэрлэх, ачаа ачих, буулгах, зорчигчдыг тээврийн хэрэгсэл рүү оруулах, гаргах, тээврийн хэрэгслийн аюулгүй хөвөлтийг хангах, эргийн зогсоол буудалд аваар осолгүй зогсол хийх, эрээс хөдлөх үеийн техник ийн аюулгүйн хэм хэмжээ дүрмийг мөрдөн хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

7. Усан замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагын ажилтан нь дараах дүрэм журмыг заавал дагаж мөрдөнө. Үүнд:

а/усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм;

б/усан замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын дотоод дүрэм болон ажлын байрны тодорхойлолт;

в/техникийн аюулгүй байдал, ариун цэврийн дүрэм;

г/усан замын тээврийн хэрэгслийн агрегат механизмын аюулгүй ажиллагаа ба хөдөлмөр хамгааллын зааварчилга.

8. Ажилтнуудын заавал даган мөрдөх дүрэм, биелэлтийг Усан замын тээврийн аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа /цаашид "захиргаа" гэх/-аас шалган холбогдох зааварчлагаар хангах үүрэгтэй.

9. Тээврийн хэрэгслийн ахмад, механик, тэдгээрийн туслахууд, цахилгааны механикч нар нь мэргэжлийн зэрэгтэй байх бөгөөд захиргаанаас тогтсон журмын дагуу мэдлэг ур чадварыг нь шалган түвшин тогтоож зааварчилгаа өгнө.

10. Захиргаа нь өөрийн ажилтан, ажиллагсдыг жил бүр эмнэлгийн үзлэгт хамруулж эрүүлжүүлэх арга хэмжээ авна.

11. Техник ашиглалтын дүрмийн заалтыг биелүүлээгүй буюу зөрчсөн этгээдэд холбогдох хууль эрх зүйн актын дагуу захиргааны арга хэмжээ авах ба гэмт хэргийн шинжтэй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

12. Усан зам болон түүний эргийн дагуу байгуулагдсан барилга байгууламж /гүүр, хаалт г.м/ нь үйл ажиллагаагаа зориулалтын дагуу хэвийн нөхцөлд явуулах боломжоор хангагдсан байхаас гадна тээврийн хэрэгслийн аюулгүй хөвөлтийн шаардлагыг биелүүлсэн байвал зохино.

13. Захиргаа нь усан замын барилга байгууламжийн хэвийн найдвартай байх үйл ажиллагааг хариуцан ажиллах үүрэгтэй.

14. Тэврийн хэрэгслийн хөвөлтийн үзлэг шалгалтыг Усан замын улсын байцаагч болон захиргаанаас томилогдсон комисс хийнэ. Усан замын онцлог хэсэгт улсын байцаагчийн үзлэгийг тээврийн улирал эхлэлийн өмнө, усны түвшин ихсэх буюу үертэй үед, намар улирлын төгсгөлд, жилд нийтдээ 3 удаа явуулна.

15. Холбогдох байгууллагаас ирүүлсэн цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ /манан, будан, салхи, шуурга, давлагаа г.м/-г тээврийн хэрэгсэлд цаг алдахгүй хүргэх үүргийг Захиргаа хүлээнэ.

16. Захиргааны болон түүний үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж шинээр объект барьж байгуулах, засвар үйлчилгээ хийж гүйцэтгэх шаардлага гарсан тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч гүйцэтгэнэ.

Гурав. Усан замын тээврийн аюулгүй хөвөлтөд тавигдах шаардлага

17. Усан замын тээврийн хэрэгслийн их биеийн уртын хэмжээг "Усан замын тээврийн тухай" хуулийн 6.1.4, 7.1.4 дэх заалт, тээврийн хэрэгслийн техник эдийн засгийн тооцоог үндэслэн тогтооно.

18. Усан замын багтаамжийн хэмжээг тээврийн хэрэгсэл болон усан замын тээврийн хэрэгслийн өвор хэмжээ, суулт, усны гүн ба голдрилын өргөнийг үндэслэн тогтооно.

19. Тээврийн хэрэгслийн хэмжээ нь батлагдсан усан замын хэмжээнд тохирч байх ёстой ба усны гүнд ёроолын гадаргууги олно.

20. Усан замын өргөний хамгийн бага хэмжээг тодорхойлохдоо:

а/ нэг чиглэлийн хөвөлттэй замд хөвөх онгоцны хамгийн өргөн хэсгийг 0.5 гэсэн итгэлцүүрээр;

б/хоёр чиглэлийн хөвөлттэй зам /зэрэгцээд хөвөх буюу зөрөх/-д хөвөх онгоцны хамгийн өргөн хэсгийг 0.3 гэсэн итгэлцүүрээр тус тус үржүүлж тодорхойлно. Усан замын тээврийн хэрэгсэл гол мөрөн дээр баригдсан гүүрний доогуур гарахдаа гүүрэн дээр тавигдсан заалт тэмдгүүдийг хатуу баримтална. Харин усан доогуур тавигдсан инженерийн барилга байгууламж, кабель, хоолойг усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтөд нөлөөлөхгүйгээр усны гүний хөрсөнд шигдүүлэн суулгаж өгсөн байвал зохино.

22. Усан замаар осол аюулгүй аялан хөвөх нөхцөлийг дараах үйл ажиллагаагаар хангана. Үүнд:

а/ёроолыг ухах малтах, тэгшлэх, цэвэрлэх замаар усны гүнийг нэмэгдүүлэх;

б/усны түвшинг шаардагдах хэмжээнд нэмэгдүүлэн тохируулах, усан сан түүний барилга байгууламж, техник хэрэгслийг байнгын ажиллагаатай болгох.

23. Захиргаа нь усан замын дохио тэмдэг ба замын тэнхлэгийг жил бүр хавар, зуны байдалд тохируулан засаж шинэчлэн зохих газруудад байрлуулна.

24. Усан замын заалт, тэмдгүүдийн хэлбэр, хэмжээ, өнгө нь улсын стандартад тохирч байх ёстой.

25. Усан замын хэвийн ажиллагааг хангах асуудлыг усан замын захиргаа хариуцна.

Үүнд:

а/усан зам ба түүний дагуу байрлах барилга байгууламж, дохио тэмдэг, усан зам харилцан бусад асуудлууд;

б/Усан замын засварын ба бүтээн босгох ажлын хугацаа, ажиллах, хүчний бүрэлдэхүүнийг тогтоож, ажлын гүйцэтгэлд шаардагдах бэлтгэлийг хангаж өгнө.

Дөрөв. Усан замын тээврийн хэрэгсэл, түүнд тавигдах шаардлага

26. Усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн агрегат механизм, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааны хяналт шалгалтыг тээврийн хэрэгслийг ахмад, механикийг байлцуулан хийж гүйцэтгэх ба аюулгүй хөвөх бүх нөхцөлийг хангасан байвал зохино.

Тээврийн хэрэгслийг их бие, агрегат механизм, тоноглол, дотоод шаталтын хөдөлгүүр, уурын тогоо, үндсэн машин, жолоодлогын ба зангууны тоноглол, усан онгоцны системүүд, гэрлэн ба дуут дохио, мачта зэрэг нь өөрийн зураг төсөл, техникийн тодорхойлолтоор "Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналт тавьж бүртгэх түр журам"-ын шаардлагыг хангасан байх шаардлагатай.

27. Шинээр ашиглалтад орж буй тээврийн хэрэгсэлд дараах шаардлага тавигдана.

Үүнд:

а/техникийн бүрэн бүтэн байдлын талаар комиссын акт гаргуулах;

б/батлагдсан орон тоогоор ажиллах мэргэжлийн баг бүрдүүлсэн байх;

в/байвал зохих бичиг баримтуудыг тээврийн хэрэгслийг техникийн паспорт, хөдөлгүүрийн баримт бичиг г.м/ бүрдүүлсэн байх;

г/тогтоосон нормын дагуу авч явах сэлбэг, багаж хэрэгсэл, эд хөрөнгө бүрэн байх.

28. Тээврийн хэрэгслийг зориулалтын бус аливаа үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно. Зайлшгүй төв байгууллагын шийдвэрээр ашиглаж болно.

29. Тээврийн хэрэгслийн ахмад, механикууд дотоод дүрмийг аяллын үед удирдлага болгон ажиллана.

30. Тээврийн хэрэгслийг өвлийн зогсоолд болон засвар үйлчилгээнд тавих бэлтгэл ажлыг дүрэмд заасны дагуу тээврийн хэрэгслийн бие бүрэлдэхүүн ахмад, механикийн удирдлаган дор хийж гүйцэтгэнэ.

Тээврийн хэрэгслийн их бие

31. Ашиглалтад байгаа тээврийн хэрэгслийн их бие болон эд ангийн элэгдэл нь тогтоосон хэмжээнээс илүүгүй байх ба элэгдлийн хэмжээг эрх бүхий байгууллага тээврийн хэрэгслийн төрөл тус бүр дээр тусгайлан тогтооно.

32. Тээврийн хэрэгслийн их биеийн хоёр хажуу усанд суух өндөр болон усны түвшингээс дээш байрлах хэмжүүрийн заалт тэмдгийг /ачаалах тэмдэг/ бүртгэлийн дүрэмд заасны дагуу зохих өнгийн будгаар будаж байрлуулна.

Ачаа

33.Тээврийн хэрэгслийн хуурай ачаа болон түүний тоноглолын бүрэн бүтэн байдлыг ахмад, механикийн зүгээс үе үе шалгаж байна.

34.Ачааны тоноглол, механизмын гэмтэлтэй аялалд гарахыг хориглоно. Хориглосон заалтад дараах тохиолдлыг оруулна. Үүнд:

а/тоормозны механизм ажиллахгүй буюу гэмтэлтэй;

б/өргүүрийн сум, тулгуур гэмтсэн буюу бэхэлгээ муу хийгдсэн;

в/олс, тороосны дамрын гол 15 болон түүнээс хувийн элэгдэлтэй.

г/ороосны 6 диаметр урт тутам утасны 10 хувь буюу нэг сүлжээ тасарсан;

д/эрэг, шураг болон их биеийн дамарт цав, гажилт гарсан.

Залгуур

35.Залгуурын тоноглол нь аяллын ямар ч нөхцөлд тээврийн хэрэгслийг найдвартай залгах үндсэн нөхцөлд болох дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

а/ороос болон залгуурын голын элэгдэл тогтоосон хэм хэмжээнээс хэтрээгүй байх;

б/ Залуурын тороосыг ямагт чангалсан байх;

в/ 0-45 градус хүртэл залуурын эргэх хугацаа механикжсан залуурын хувьд 30 секунд, гар ажиллагаатай залуурын хувьд 2 минутаас ихгүй байх;

г/ үндсэн залуураас нөөц залуурын ажиллагаанд шилжих хугацаа нэг минутаас хэтрэхгүй байх;

д/жолоодогчийн палуб /тавцан/, онгоцны тавцантай үрэлдэхээргүй зайтай, арааны элэгдэл нь хэвийн ажиллагаанд нөлөөлөхгүй байх;

е/ залуурын машины цахилгааны контактууд цэвэр найдвартай ажиллагаатай байх;

36. Тороос, олсны чанарын шалгалтыг хийлгээгүйгээр ашиглахыг хориглоно.

37. Тээврийн хэрэгсэл хайргадах болон залгуур ямар нэгэн зүйлд хүчтэй хүрсэн тохиолдолд ахмад, механик үзлэгийг чанд нямбай, чанартай хийж гүйцэтгэх ба хэрэв эвдрэл гарсан бол нөхцөл, шалтгааныг тогтоох үүрэг хүлээнэ.

38. Залуурын ажиллагаа гэмтэлтэй тээврийн хэрэгслийг аялалд гарахыг хориглоно.

Зангуу

39.Аяллын ямар ч нөхцөлд зангууг яаралтай буулгах ба татахад бэлэн байх шаардлагыг хангахын тулд дараах нөхцөлийг биелүүлсэн байна:

а/зангуу хураагч нь 2 зангууг нэгэн зэрэг тогтоосон хугацаанд татаж авах хүчин чадалтай байх;

б/ зангууны гинжийг хайрцагт хураан төгсгөлийг онгоцны их биед найдвартай бэхэлсэн байх;

в/гинжний металлын диаметрийн элэгдэл 20%-аас хэтрэхгүй байх;

г/зангуу хураагч болон шпилийн тоормоз, гинжний түгжээ найдвартай байх.

40.Зангуу нь бүрэн бус ажиллагаатай тээврийн хэрэгслийг хөвөлтөд гаргахыг хориглоно.

Татлага, оосор

41.Татлагын шон, гогцоо, бэхэлгээ найдвартай байх ба татлага, оосорт гэмтэл учруулж болохуйц хурц ирмэг, огцом нугалаа үүсээгүй байх.

42.Тороосны 8 диаметрийн урт тутам утасны тасархай 30 хувиас хэтрээгүй байна.

43. Чанарын хувьд тохироогүй татлагын тороосыг чирэх тороосонд хэрэглэхийг хориглоно.

Чирэгч холбоос

44. Чирэгчийн гак, арк найдвартай бэхлэгдсэн байхаас гадна түгжээ чирэгчийг яаралтай салгах төв удирдлагаар хангагдсан байна.

45. Нэгдүгээр зэргийн нефть шатахууны онгоцонд шатахуун тээврийн дүрэмд дурдсан татлага, оосор хэрэглэнэ.

46. Чирэгчийн тороосны 8 диаметрийн урт тутам элэгдэл 10 хувиас илүүгүй байна.

47. Аялалд гарахын өмнө чирэгчийн эд анги болон удирдлагын механизмын ажиллагааг ахмад өөрийн биеэр шалгаж, бүрэн бус тохиолдолд хөвөлтөд гарахыг хориглоно.

Мачта /цамхаг/

48. Тээврийн хэрэгслийн цамхгийн өдөр, шөнийн дохио, радио антена, буулгах, босгох механизм ямагт бүрэн ажиллагаатай байна.

49.Гадна харилцааны өдөр, шөнийн дохионууд /яндан, дохио (сирен), дэнлүү, дохио өгөх туг, хонх/ цаг агаарын ямар ч нөхцөлд сонсогдохуйц, үзэгдхүйц байхаар тоноглогдсон байна. Тээврийн хэрэгслийн дохиог зориулалтаас өөр зүйлд хэрэглэхийг хориглоно.

50. Тээврийн хэрэгслийг гадна болон дотор талд байрлах харилцаа холбооны хэрэгслийн ажиллагааг аялалд гарахын өмнө ахмад өөрийн биеэр шалгаж бэлтгэсэн байх ба дутагдал, гэмтэл илэрсэн тохиолдолд хөвөлтөд гарахыг хориглоно.

Аврах ажиллагаа

51. Аврах хэрэгслийн тоо, чанар, тэдгээрийн байрлал тогтоосон хэмжээнд нийцэж байвал зохино.

52. Тээврийн хэрэгслийг аялалд гаргахын өмнө аврах хэрэгслийн бүрэн бүтэн байдал болон "Усанд хүн уналаа" сургуулийн түгшүүрийг ахмад удирдан явуулж энэ тухай тэмдэглэл хөтөлсөн байна. Энэ сургуулилтыг дараах шаардлагын дагуу явуулна. Үүнд:

а/зангуу татах, буулгах механизм тогтоосон хугацаанд хэвийн ажиллагаа үзүүлж байх;

б. Хамгаалах цагираг хөвүүр бүрэн байх ба аврах завинд ус шүүрэхгүй байх.

53.Дор дурдсан алдаа дутагдал илэрсэн тээврийн хэрэгслийг аялалд гарахыг хориглоно. Үүнд:

а. Аврах хэрэгслийн тоо хэмжээ тогтоосон тоо хэмжээнд хүрэхгүй байх;

б/аврах хэрэгслийн техникийн байдалд хяналтын байгууллага хангалтгүй үнэлгээ өгсөн;
в/буулгах механизмын ажиллагаа хэвийн бус, буух хугацаа тогтоосон хугацаанаас хэтэрсэн.

Аяллын хэрэгсэл

54. Ашиглалтад байгаа тээврийн нэг бүрийг бүртгэлийн журмын шаардлагад заасан эд ангиар хангасан байна.

55. Луужингийн бүрэн бус ажиллагаатай, хянагдаагүй замын зураг бүхий тээврийн хэрэгслийг нуур, далай зэрэглэлтэй усан замар аялахыг хориглоно.

Гал унтраах хэрэгсэл

56. Гал унтраах бүх хэрэгсэл нь гарын дор газар байрлуулагдсан байх ба хэрэглэхэд байнгын бэлэн байдал байна. Гал унтраах хэрэгслийг зориулалтын бус үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглоно.

57. Түргэн шатаж дэлбэрэх зэрэглэл бүхий аюултай ачаа /нефть болон бусад/ барааг тухайн төрлийн ачаа тээвэрлэхэд мөрддөг дүрмийн дагуу гал унтраах хэрэгслээр тоногдсон байх шаардлагатай.

58. Гал унтраах багаж хэрэгсэл бүрэн бус ажиллагаатай болон холбогдох журмын шаардлагад нийцээгүй тохиолдолд аялалд гаргахыг хориглоно.

Тээврийн хэрэгслийн машин механизм

59. Тээврийн хэрэгслийн үндсэн машин, тоног төхөөрөмж, өөрийн ашиглалтын хугацаанд тасралтгүй ажиллагааг хангаж байхаас гадна тэдгээрийн туслах механизмууд ажиллагаанд цаг ямагт бэлэн байна.

60. Жолоодлогын байрны болон машин ангийн хяналт, хэмжүүрийн самбарын хэрэгсэл бүрэн бүтэн ажиллагааг хангасан байна.

61. Тээврийн хэрэгсэлд усны, уурын, түлш, тос, агаар дамжуулалтын хоолой болон цахилгаан шугамын схемүүд байх ёстой.

62. Тээврийн хэрэгсэлд байрлуулсан хэмжүүрийн бүх хэрэгслийг жин хэмжүүрийн эрх бүхий байгууллагаас баталгаажуулан лацадсан байх бөгөөд ашиглалтын үед тогтоосон хугацаанд хяналт шалгалт хийж байна.

63. Тогооны болон бусад даралтад савны хамгаалах хавхлагыг эрх бүхий этгээдээр лацдуулна.

64. Тээврийн хэрэгслийн механизмд дараах зүйлийг хориглоно. Үүнд:
а/ тухайн нөхцөлд даралттай байгаа тогоо болон бусад даралтат савыг засварлах;
б/эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр даралтын ба бусад хэмжүүрийн хэрэгслийг байршлыг өөрчлөх, тохиргоо хийх.

65. Тээврийн хэрэгслийн механик ашиглалтын зааварт дурдсан хугацаанд машин механизм бүрийн эд ангийн элэгдлийг тооцоолж, дүнг журналд тэмдэглэнэ.

66. Жолоодлогын байр ба машин, тогооны ангид байрлуулсан хэмжүүрийн тоног төхөөрөмжийг гэрэлтүүлэх аваарын хэрэгслээр тоногдсон байна.

67. Механизм, систем бүрийн нээхийг зориулалтын тэмдгээр харуулан дотор нь агуулагдах ус, уурын хөдөлгөөний чигийг сумаар заана.

68. Тээврийн хэрэгсэл бүрийн машины ангид тусгай маягтын дагуу батлагдсан машины журнал байх ба хөтлөлтийг ерөнхий механик хариуцна.

Дотоод шаталтын хөдөлгүүр

69. Үндсэн ба туслах хөдөлгүүрийн түлш зарцуулалт өөрийн хүчин чадлын хэмжээнээс хэтрэхгүй байх ба дараах шаардлагыг хангана. Үүнд:

а/ эргэлт хязгаарлагч, хамгаалагчийн найдвартай ажиллагаа;

б/ хөдөлгүүр тосолгоо хийгдсэн, хөргөлтийн болон түлшний системүүдийн ажиллагаа хэвийн байх;

в/хөдөлгүүрийн хүчийг цилиндр бүрт жигд тохируулах;

г/ хөдөлгүүрийн эргэлтийг тогтоосон хэмжээнд байлгах.

70. Үндсэн ба туслах машин механизмууд жолоодлогын автомат хамгаалалт бүхий төв удирдлагатай бол машин ангиуд ээлжгүй ажиллаж болно.

71. Үндсэн ба туслах хөдөлгүүрт дараах гэмтэл гарсан нөхцөлд ажиллуулахыг хориглоно. Үүнд:

а/ цилиндрийн гавал, втулка, хөдлөх эд анги, масло, түлш болон хийн хоолой цав гарсан;

б/машин эргэлт, шилжүүлэлт болон моторын эд ангид гэмтэл гарсан;

в/ эргэлтэд хязгаарлагчид гэмтэл гарсан;

г/ цилиндрээс хий алдсан;

д/хөдлөх эд ангиудад хэвийн бус чимээ, цохио гарах болсон;

е/агаар шахалт хэвийн бус хэмжээтэй байх;

ж/ цилиндр, картер ба тосны системд ус орсон;

з/цилиндрийн гавлын хамгаа лах хавхлагийн тохиргоо алдагдсан;

и/тос, түлш болон хөргөлтийн шахуургуудын ажиллагаа алдагдсан.

72. Бүх даралтат савыг тогтоосон хугацаанд заавал шалгаж байна.

Хийн шахуургын төхөөрөмж

73. Шахагдсан хийн балл оны тоо, ширхэг, багтаамж нь үндсэн туслах хөдөлгүүрүүдийг асаах, эргэлт шилжүүлэхэд хүрэлцэхүйц тоо хэмжээтэй байна. Дараах баллонд шахалт хийхийг хориглоно.

а/ цав гарсан, хий гарсан;

б/даралт хоногт 10 хүртэл хувиар буурч хий алдагдсан;

в/хамгаалах хавхлаг ба манометр гэмтэлтэй;

г/тослог, уур, чийг гаргах илүү хоолой байрлуулаагүй.

74. Баллоныг цэнэглэх бүрийн өмнө цэвэрлэнэ.

75. Хийн шахуургад дараах гэмтэл тохиолдвол ажиллуулахыг хориглоно.

а/үндсэн эд ангиудад гажилт, цууралт, цав үүсэн;

б/агаарын хоолойнууд хий алдсан;

в/тосны ба хөргөлтийн системд гэмтэл гарсан;

г/хамгаалах хавхлагад тохиргоо хийгдээгүй буюу гэмтэлтэй;

д/хөдлөх эд ангиудад хэвийн бус цохио, чимээ үүссэн.

Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн төхөөрөмжүүд

76. Ахмад тээврийн хэрэгслийг аялалд гарахын өмнө техникийн үзлэг хийх ба дараах зөрчил дутагдал илэрвэл хөвөлтөд гаргахыг хориглоно. Үүнд:
а/тээврийн хэрэгслийн онгоцны туслах механизмууд цахилгаан хөдөлгүүртэй бол ерөнхий цахилгаан үүсгүүрийн нэг нь ажиллагаагүй болсон;
б/аваарын цахилгаан үүсгүүр гэмтсэн;
в/залуур, тэжээгч шахуурга, хөргөлтийн системийн шахуургын хөдөлгүүр гэмтсэн;
г/дохионы гэрэл, гэрэлтүүлэг ажиллагаагүй болсон;
д/сэнсний далбаа хугарсан, боолтын шплинт муудсан.

77. Усан онгоцны бүх цахилгаан тоноглол техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангасан байна.

78. Тээврийн хэрэгслийн цахилгаан тоноглолын ажиллагаа нь радио дамжуулалт буюу радар, луужингийн хэвийн ажиллагаанд нөлөөлөхгүй ажиллагаатай байх ба цахилгаан гаралт тасалдах, оч үсрэх, хэт халах гэх мэт аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.

79. Бүх цахилгаан тоноглолын үзлэгийг хийхдээ гүйдлийг салгасны үндсэн дээр сард нэгээс доошгүй удаа зохих журам, зааврын дагуу гүйцэтгэнэ.

80. Утас, кабелийн бүрхүүлийн чанар, цахилгаан машин, аппаратын хуваарилалтын самбарыг шалгахад цахилгаан гүйдлийг заавал салгасан байна.

81. Аваарын гэрэл богино хугацаанд асаж байгаа эсэхийг байнга шалгана.

82. Тээврийн хэрэгсэл нь цахилгаан хэмжих багаж хэрэгслээр хангагдсан байх ба заалтын хэмжүүрийг 2 жилд 1 удаа, эргэлзсэн нөхцөлд тухай бүрт Улсын жин хэмжүүрийн газарт шалгуулна.

83. Нэг цахилгаан үүсгүүрийн ачааллыг нөгөөд шилжүүлэлгүйгээр ажиллагааг зогсоохыг хориглоно.

84. Цахилгаан самбарын өрөөнд зайлшгүй байх эд зүйлийн жагсаалт:

а/нөөц гал хамгаалагч, дохионы буюу хяналтын гэрэл;

б/засварын багаж;

в.резин бээлий ба дэвсгэр, нүдний шил, хамгаалах бүрхүүлтэй багаж;

г/эмийн сан;

д/галын хор;

е/гар чийдэн, шаардлагатай багаж, түлхүүрүүд.

85. Цахилгаан машиныг дараах тохиолдолд ажиллуулахыг хориглоно. Үүнд:

а/кабель утасны гадаргуу халсан;

б/цуглуулагч /коллектор/-д 2 баллаас дээш оч үсэрсэн;

в/асаах ба тохируулах аппарат хэрэгсэл ажиллагаагүй болсон;

г/машиныг гэмтээж болох үрэлт, цохио үүссэн;

д/зангууны ороомогт богино холбоо үүссэн.

86. Цахилгаан хөдөлгүүрийг дараах тохиолдолд даруй зогсоох арга хэмжээ авна. Үүнд:

а/хөдөлгүүр халах, хиншүү үнэртэх, утаа ба гал гарах;

б/хөдөлгүүрийн галын гажилтаас доргио, чичиргээ үүсэн;

в/хөдөлгөөнтэй эд ангид хүний хувцас татагдсан.

87. Хамгаалах хэрэгслийн хүчинтэй хугацаа тогтмол шалгаж байх ба зориулалтаас өөр шалтгаанаар ашиглахыг хориглоно.

88. 25 вт-аас хүчдэлтэй бүх цахилгаан тоноглолын төмөрлөг хэсгийг заавал газардуулсан байна.

89. Хүчдэлийг салгасны дараа гал хамгаалагчийг сольж хэвшинэ. Хэрэв ийм бололцоогүй бол ачааллыг бууруулж хамгаалах хэрэгслийг солино.

90. Зөөврийн гэрлийг нефть, шатахуун тээвэрлэгч онгоц болон шатаж дэлбэрэх ачааны ойролцоо хэрэглэхийг хориглоно. Мөн өндөр хүчдэлээс аль болох хол байлгаж гэрлийг анхаарал болгоомжгүйгээс түүнд холбохгүй байх ба бүрхүүлд нэвчихгүй байх нөхцөлөөр хангана.

91. Усан замын тээвэр эрхэлж буй тээврийн хэрэгсэл өөрийн радио холбооны станцыг ашиглан мэдээлэл солилцож, эрэг, зогсоол, буудлын диспетчертэй байнгын холбоотой байна.

92. Радио холбооны станцыг ашиглахад дараах баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

а/радио холбоо ашиглах зөвшөөрөл;

радио станцын гэрчилгээ;

в/ээлжийн журнал;

г/нэвтрүүлгийн долгионы хуваарь;

д/радио холбооны дүрэм;

е/техникийн аюулгүйн дүрэм;

ё/ашиглалтын дүрэм ба заавар.

93. Тээврийн хэрэгслийн радио холбоог зохих мэргэжлийн хүн ажиллуулах бөгөөд холбооны хэвийн ажиллагааг найдвартай хангаж, техникийн үзлэгийг тогтмол хийнэ.

Аяллын чиглэл

94. Аяллын чиглэл, замнал нь усан замын тээврийн хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, үйлчилгээгээр иргэдийг хангах, зорчигч болон ачаа тээвэрлэлтийг бага зардлаар өндөр бүтээмжтэй зохион байгуулахад чиглэгдсэн, батлагдсан төлөвлөгөө юм. Хөдөлгөөний чиглэлийг засаг захиргаа, усан замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталснаар хүчин төгөлдөр болж, аяллын бүх хугацаанд багийн бүрэлдэхүүний заавал мөрдөх журам болно.

Усан онгоцны засвар

95. Гол мөрний тээврийн хэрэгслийн засварыг төлөвлөгөөний дагуу багийн бүрэлдэхүүний хүчээр хийж гүйцэтгэх бөгөөд засварыг дотор нь урсгал, дунд ба их засвар гэж ангилна.

96. Тээврийн хэрэгслийн өвлийн зогсолтын хугацаанд хийх урсгал ба дунд засварыг засварын нэгдсэн мэдээг үндэслэн тогтооно.